



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/193

Бат-Өлзий сум

**Мал, амьтны гоц халдварт “Мялзан” өвчнөөс
урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар үйлийн 32.1.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/647 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бог малын гоц халдварт “Мялзан” өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн 14 хоногийн дотор зохион байгуулж ажиллахыг “Хустын рашаан”, “Хутагт уулын өгөөж” мал эмнэлгийн нэгжүүдэд үүрэг болгосугай.

2.Бог малын гоц халдварт “Мялзан” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг заасан хугацаанд зохион байгуулах, хяналтын баг, вакцинжуулалт хийх ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, мялзан өвчний дархлаажуулалтын ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дархлаажуулалтын товыг малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нарт зарлан мэдээлж ажиллахыг багийн Засаг дарга (Ж.Нямтогтох, Д.Бямбасүрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Г.Бямбагарав, Д.Дэмиддагва) нарт үүрэг болгосугай.

4.Бог малын гоц халдварт “Мялзан” өвчний халдварлалтыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээнд вакцины дархлаа тогтоох хүртэл хугацаанд отор нүүдлээр явах, малчдын нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнийг зогсоосугай.

5.Малын гоц халдварт “Мялзан” өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт вакцинжуулалтын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч (П.Аюушжав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

622301300

Сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр
сарын 27-ны өдрийн А/193 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ХЯНАЛТЫН БАГ

Хяналтын багийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)
Гишүүд: Г.Сугар (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжилтэн)
П.Аюушжав (Мэл эмнэлгийн тасгийн дарга)

ВАКЦИНЖУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

1 дүгээр хэсэг (1, 2, 6 дугаар баг)

Ажлын хэсгийн ахлагч: Л.Батчулуун ("Хустын рашаан" мал эмнэлгийн
үйлчилгээний нэгжийн малын их эмч)
Гишүүд: Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)
Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)
Б.Батбилэгт ("Хустын рашаан" мал эмнэлгийн
үйлчилгээний нэгжийн эзэн)

2 дугаар хэсэг (3, 4, 5 дугаар баг)

Ажлын хэсгийн ахлагч: П.Содномбалжир ("Хутагт уулын өгөөж" ХХК-ны
малын их эмч)
Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)
Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)
Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)
Туслах ажилтан (Дөрвөн иргэн)
Хөдөө аж ахуйн тасаг

---oOo---

Бат-Өлзий сумын Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 27-ны өдрийн А/193 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	МЭҮНэгжүүдийн нэр	Баг	Хамрагдах малын тоо төрөл	Хамрагдах малын тоо
1.	Хустын Рашаан	1, 2, 6 дугаар баг	Хонь	51301
			Ямаа	18755
			Хурга	24600
			Ишиг	8590
			Бүгд	103246
2.	Хутагт-Уулын-Өгөөж	3, 4, 5 дугаар баг	Хонь	47029
			Ямаа	20146
			Хурга	26277
			Ишиг	9902
			Бүгд	103354
Сумын дүн:		1, 2, 3, 4, 5, 6 дугаар баг		206600

---оОо---

Бат-Өлзий сумын Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 27-ны өдрийн А/193 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

**БОГ МАЛЫН МЯЛЗАНГИЙН ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖИЛД ШААРДЛАГАТАЙ
ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Ажиллах хоног	Удирдах албан тушаалтан	МЭТасаг	Малын эмч	Санитарч, техникч	Туслах ажилтан баригч	Жолооч	Нийт
1	20	8	1	3	2	2	2	18

3

ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, БАГАЖ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

№	Зардлын нэр төрөл	Хэмжээ	Шаардлагатай тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Ажлын бээлий	ш	50	3000	150000
2	Маск	ш	50	2000	100000
3	Хурууны лент /бүдүүн/	Хайрцаг	6	5000	30000
4	Хагас автомат	ш	2	100000	200000
5	Бүрэн автомат шприц	ш	2	195000	390000
6	Спирт	ш	4	30000	120000
7	Нэг удагийн ком ХХХувцас	ш	10	18000	180000
6	Шуудан холбоо	ш	7	20000	140000
7	Бусад				350000
8	Туслах ажилтан	Хүн, өдөр	4 хүн 7 хоног	70000	1960000
	Бүгд:				3620000

ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

№	Төрөл	Туулах км	Шаардагдах шатахууны хэмжээ /л/	Нэг литрийн үнэ	Нийт мөнгөн дүн
1	1-р баг /машин/	500	100	3590	359000
2	2-р баг /машин/	550	110	3590	394900
3	3-р баг /машин/	150	20	3590	71800
4	4-р баг /машин/	450	60	3590	215400
5	5-р баг /машин/	80	10	3590	35900
6	6-р баг /машин/	800	160	3590	574400
7	Нөөц түлш		12	3590	43080
8	Хяналтаар явах /машин/	550	110	3590	394900
	Бүгд	3080	582	3590	2089380

---о0о---